



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№52 /496/

2023.03.29


Цаг үе, үйл явдал

ХУРАНДАА ЭДАН МОРАГЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



Батлан хамгаалах яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга хурандаа Б.Бат-Эрдэнэ Израил Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа Элчин сайдын яамны Монгол Улсад хавсран суугаа Батлан хамгаалахын атташе хурандаа Эдан Морагыг Монгол Улсад ажлын айлчлал хийж байгаатай холбогдуулан хүлээн авч уулзлаа.

Уулзалтаар хоёр орны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны өнөөгийн түвшин, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцлоо.



"НИЙГЭМ БИДНЭЭС ХАРИЛЦАА, ХАНДЛАГААРАА ҮРГЭЛЖ МАНЛАЙЛАХЫГ ШААРДАЖ БАЙНА"



Батлан хамгаалахын сайдын дэргэдэх "Иргэний зөвлөл"-ийн нарийн бичгийн дарга, хошууч А.Октябриар ахлуулсан ажлын хэсгийнхэн 3 дугаар сарын 28-ны өдөр Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалд "Монгол эр хүний харилцаа хандлага, ёс зүй, цэргийн алба хаагчийн манлайлал" сэдэвт уламжлалт сургалтаа хагас өдрийн туршид зохион байгуулж явууллаа.

Сургалтын эхэнд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн Ажлын албаны мэргэжилтэн, хошууч А.Октябрь Батлан хамгаалахын сайдын дэргэд "Иргэний зөвлөл" байгуулагдах болсон шалтгаан нөхцөл, түүний ажиллах журам, явагдсан сургалт, нөлөөлөл, сурталчилгааны ажил, арга хэмжээний талаар мэдээлэл өглөө. "Иргэний зөвлөл" нь 2021 онд ажиллах журмаа баталгуулжсанаас хойш хамгийн эхний ажил нь Батлан хамгаалах яаманд 24 цагаар "1800-1144" тусгай дугаарыг ажиллуулав. Энэ нь батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд хандах иргэдийн санал гомдлыг шуурхай шийдвэрлэх, хариу өгөхөд чиглэсэн бөгөөд алба хаагчдад ч нээлттэй тусгай дугаар гэж тодотголоо. Дараагийн томоохон ажил нь ҮБХИС-ийн материаллаг баазыг түшиглэж салаа, салбарын офицеруудтай вакум сургалтыг зохион байгуулав. Энэ нь хугацаат цэргийн алба хаагчидтай тулж ажилладаг офицер, ахлагчийн харилцаа хандлага ямар байхыг сургасан ба цаашдаа хүрээгээ тэлж, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын захирагчийн орлогч нарыг хамруулахаар төлөвлөж байгаа ажээ.

Мөн алба хаагчдын ёс зүйг дээшлүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эх оронч үзэл хүмүүжлээр төлөвшүүлэх чиглэлээр "Иргэний зөвлөл"-ийн нийгэмд гүйцэтгэсэн үүргээрээ танигдаж алдаршсан эрдэмтэн, хуульч, зохиолч, багш нараас бүрдсэн 13 гишүүн Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад 2022-2023 онд уулзалт, сургалтыг тасралтгүй зохион байгуулсныг онцлолоо. Ингэхдээ нийгмийн хөгжлийн чин хандлагаас хамааран социал сүлжээнд "Эх оронч үзэл, ёс зүйтэй иргэн байх тухай" контентууд бэлтгэн түгээж, өдгөө Зэвсэгт хүчээр хязгаарлагдахгүйгээр төрийн цэргийн болон боловсролын байгууллагад

сургалтаа зохион байгуулж байгааг ярилаа. Мөн тэрээр үргэлжлүүлэн Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн бодлого, үйл ажиллагаа, онцлох ажлууд, 2023 оны зорилтын тухай мэдээлэл хүргэв.

Энэ онд "Хөдөлмөрийн аюулгүй байдал", "Цэргийн алба манлайлал", "Дураараа биш дүрмээрээ", "Ёс зүй харилцаа, хандлага" сэдвийн хүрээнд зарим салбар нэгж, байгууллагуудтай хамтран томоохон ажлууд зохион байгуулна гээд өнгөрсөн онд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хяналт шалгалтын нэгдсэн мэдээллийн сантай болсон гэв. Нэгдсэн мэдээллийн санд Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд улирал бүр цэргийн алба, сахилга хариуцлагын тоон мэдээ, сайшаал урамшуулал, санхүүгийн тооцоогоо хүргэх гэнэ. Хошууч А.Октябрь "Нийгмийн чиг хандлага биднээс харилцаа хандлагаа өөрчлөхийг шаардаж байгаа учраас дарга төвтэй бус менежер төвтэй болоход бүх түвшиндээ анхаарах хэрэгтэй" гээд сургалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн командлалын удирдлагуудад талархал илэрхийллээ.

Дараагийн лекц нь Монгол Улсын Ардын багш, Гавьяат багш, шинжлэх ухааны доктор, профессор, ҮБХИС-ийн тэргүүлэх профессор, бэлтгэл хурандаа Г.Мягмаржав багшийн "Монгол эр хүн" сургалт байв. Багш Зэвсэгт хүчний олонхыг бүрдүүлсэн эрчүүд ямар байх ёстойг сургааль, дуу, шүлэг, зүйр үгээр лекцээ хослуулан бэлтгэсэн нь сургалтад хамрагдсан бүрэлдэхүүнд тун ойлгомжтой байв.

Тэрээр лекцээ "Монгол эр хүн" дуугаар эхлүүлж, төгсгөлд нь өөрийн шавь ҮБХИС-ийн ЦНДС-ийн Артиллерийн командын гуравдугаар дамжааны сонсогч О.Алтаншагайтай мөн л эр хүний дуугаар өндөрлүүлсэн ба үүний дунд нь шигтгээ болсон олон сургамжийг өгүүллээ. Тухайлбал, эр хүний гурван тулгуур зарчим нь хамгаалах, хайрлах, нийгэмших. Эрүүл мэнд, гэр бүл, тусгаар тогтнолоо хамгаалж, хуулийн дор амьдарч, эх орныхоо төлөө хугацаат цэргийн албаа хаах нь эр хүн бүрийн заавал гүйцэтгэх үүрэг. Энэхүү үүргээ биелүүлсэн эр хүний цээжинд эх орноо хайрлах үзэл бат суудаг учраас энэ дамжлагыг заавал

дамжих ёстойг онцлолоо.

Үргэлжлүүлэн цэргийн алба хаагчийг удирдах, сургах тухай ярихдаа "Өнөөдөр хүчээр, өндөр дуугаар захирснаараа сайн дарга болохгүй. Ууртай, омог бардам зангаар цэргээ сургадаг тогтолцоо хоцрогдсон. Үүний бодит жишээг "Оюутан цэрэг" сургалтаас харж болно. Хэзээ ч хатуу үгээр мохоож, орилж чарлан захирах бус сэтгэлгээнд нь л юм үлдээх гэж бид хичээдэг. Үр дүнгээ ч өгдөг. "Чулуу чулуугаа дийлэхгүй, чулууг ус дийлдэг" гэдэгчлэн зөөлөн нь хатуугаа гэдэг зарчмаар манай залуу офицер, дарга нар ажиллах ёстой гэв.

Үүнээс гадна "Тэргүүний байлдагч" гэж хувь хүнийг өргөмжлөхөөс илүүтэй "Тэргүүний тасаг", "Тэргүүний салаа", "Тэргүүний рот" гэдэг хамт олонч нөхөрсөг уур амьсгалыг бэхжүүлсэн соёл хүмүүжлийн ажлыг явуулж бай. Би биш бид гэдэг хүмүүжил хамгийн чухал гээд "Дээдэд зусаргүй, доодод найртай", "Эр амгалан бол гэр амгалан" сэдвийн хүрээнд ёс зүйтэй цэргийн алба хаагчаас гадна халамжит хань, сайн эр хүн байхын тухай дурдав. Лекцийнхээ төгсгөлд цэргийн дарга нарын үүрэг алба хаагчдаа хамгаалах, сургах явдал. Өөрөөр хэлбэл, "Яс"-ны цэрэг хүн бэлтгэх нь цэргийн даргын үүрэг. Энхийг сахиулах ажиллагаанд явж ирчихээд өргөдлөө өгөөд гардаг ахлагч нарыг би ойлгодоггүй. Энэ бол албандаа чин үнэнчээр зүтгэх хүмүүжил дутуу байгаатай, нөгөө талаар сургалтын тогтолцоонд анхаарах асуудал байгааг илтгэж байна гэлээ.

"Иргэний зөвлөл"-ийнхний сургалтын үеэр ЦДБЭЧ-ын гоцлол дуучин, СТА, ахлагч Д.Батнасан "Эр хүн", "Мөрдэс гоёсон бүсгүй", СТА, ахлагч Э.Гантулга "Торгон хилийн манаа", "Баярын жагсаал" дуугаар бүрэлдэхүүнд бэлэг барьж, арга хэмжээг чимэв.

Арга хэмжээний төгсгөлд командлалын Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга, хурандаа Д.Өлзийбаяр сонирхолтой бөгөөд өгөөжтэй сургалт явуулсан "Иргэний зөвлөл"-ийнхөнд талархал дэвшүүлж, цаашдын ажил албанд нь өндөр амжилт хүссэн юм.

Ахмад Д.БОЛОР

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
13	-6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
40	28

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,515	3,522
EUR	3,820	3,835
CNY	513	515
RUB	45.40	45.70
JPY	26.90	27.10
KRW	2.71	2.73

ЗУРХАЙ

2023.03.29 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 8

ХАВРЫН ДҮНД ХӨХӨГЧИН ТУУЛАЙ САР ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ УЛААН НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Нас уртасна
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
06.38-19.17
Барилдлага:
Рашаан
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
САНСАР

САНСАР



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 683,539,740

Эдгэрсэн

Нийт: 656,504,357

Нас барсан

Нийт: 6,828,514


Цаг үе, үйл явдал

АВЛИГА, АВЛИГЫН ШАЛТГААН НӨХЦӨЛ”,
“ТӨРИЙН АЛБА ХААГЧИЙН ЁС ЗҮЙ” СЭДВЭЭР...



БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Батлан хамгаалах яамны 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд “Шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг болон ёс зүйн сургалтад хамруулсан байх” талаар тусгагдсан байдаг. Тус заалтын хүрээнд БХЯ-ны СБТГ-ын Хуулийн хэлтэс, БХЯ-ны Төрийн алба хаагчийн ёс зүйн зөвлөл хамтран “Авлига, авлигын шалтгаан нөхцөл”, “Төрийн алба хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулж, Батлан хамгаалах яаманд шинээр томилогдсон 11 алба хаагчийг хамрууллаа.

2023 ОНЫ АНХДУГААР ХУРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Өчигдөр буюу энэ сарын 28-ны өдөр Батлан хамгаалах яамны дэргэдэх Жендэрийн салбар зөвлөлийн 2023 оны анхдугаар хуралдаан боллоо.

Энэхүү хуралдаанд БХЯ-ны СБТГ-ын дарга, салбар зөвлөлийн орлогч дарга хурандаа Ч.Гандирваа, ГХАГ-ын дарга, салбар зөвлөлийн гишүүн хурандаа Б.Бат-Эрдэнэ, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга хурандаа Ж.Өсөхбаяр болон яамны харьяа аж ахуй нэгж байгууллагуудын дарга нар оролцлоо.

Хуралдааны эхэнд, салбар зөвлөлийн орлогч дарга хурандаа Ч.Гандирваа нийт бие бүрэлдэхүүнд Батлан хамгаалах сайдын 2022 оны “Жендэрийн салбар зөвлөлийн ажиллах журам батлах тухай” тушаалыг



танилцуулж, анхаарч ажиллахыг чиглэл болголоо.

Үргэлжлүүлэн БХЯ-ны дэргэдэх Жендэрийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга ахмад Ц.Хишигсүрэн Жендэрийн салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ болон 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцууллаа.

Хуралдааны төгсгөлд салбар зөвлөлийн гишүүдэд БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуягийн “Батлан хамгаалах салбарт жендэрийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэхэд цаашид анхаарах зүйлсийн талаарх үүрэг, чиглэлийг уншиж, танилцууллаа.

ЖЕНДЭРИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ



Цахим шууданд

АХМАД ДАЙЧДАА АЛДАРШУУЛЪЯ



“Алсын хараа, Эрхэм зорилго-Суралцахуй” сэдвээр Дэлхийн Мөрөөдлийн Сургуулийн үүсгэн байгуулагч, олон улсын аудитор, зөвлөх, сургагч багш Б. Мөнхдэлгэр нар илтгэл сургалт зохион байгууллаа.

Мөн энэ үеэр хүрэлцэн ирсэн зочид, төлөөлөгчид, ахмад дайчид БНМАУ-ын Маршал, Өрлөг жанжин Г.Дэмидийн хөшөөнд цэцэг өргөн хүндэтгэл үзүүлж түүний нэрэмжит тэнхимээр зочиллоо. Арга хэмжээний төгсгөлд

ангийн удирдлагын төлөөлөл хэлсэн үгэндээ “Монгол төрийн хийморь хүч болсон Хар тугийн эзэд, тангарагтаа үнэнч ахмад буурлуудаасаа ихийг ойлгож ухаарсан, урмын үг сонссон үйл ажиллагаа болж өндөрлөснийг онцлоод “Матадын дайчид НҮТББ”-ын хамт олон мөн бидний хүсэлтийг хүлээн авч дэмжлэг, туслалцаа үзүүлсэн ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямбад баярлаж, талархсанаа илэрхийлсэн юм.

Зэвсэгт хүчний 186-р нэгтгэл, тус нэгтгэлийн “Ахмадын зөвлөл”, “Матадын дайчид” НҮТББ хамтран ахмад дайчдаа алдаршуулж тэдний үйлс, гавьяаг ирээдүй хойч үедээ таниулан сурталчлах үүднээс “Одонгоо зүүцгээе-Андуудаа” өдөрлөгийг зохион байгууллаа.

Арга хэмжээний хүрээнд хугацаат цэргийн алба хаагчдад “Эх орноо хайрлан хамгаалах” сэдвээр бэлтгэл дэд хурандаа Б.Мөнхжаргал, “Эрүүл мэнд-хэрхэн урт наслах вэ” сэдвээр Ард түмний гавьяат эмч Ч.Шараа, “Ёс зүй Этик-Хүн өөрийгөө бүтээх үнэ цэнэ” сэдвээр “Матадын дайчид” НҮТББ-ыг үүсгэн байгуулагч гүйцэтгэх захирал Д.Амараа,



Цахим шууданд

“ОЮУТАН ЦЭРЭГ-2023”
СУРГАЛТАД 1500 ОЮУТАН
ХАМРАГДАНА



Засгийн газрын ээлжит хуралдаан 2023 оны гуравдугаар сарын 29-ний өдөр болж, “Оюутан цэрэг” сургалтад хамрагдах оюутны тоог нэмж, 1500 болгох шийдвэр гаргалаа.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ их, дээд сургуулийн багш, оюутан залуусын төлөөлөлтэй уулзалт хийсэн. Уулзалтын үеэр

гарсан санал, хүсэлтийг Засгийн газрын өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэж зарим шийдвэрийг гаргалаа.

Цэргийн сургуулиас бусад “Оюутан-цэрэг” хөтөлбөрт хамрагдах их, дээд сургууль, коллежийн оюутны тоог 2023 онд 1500 болгож, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг холбогдох сайд нарт даалгалаа.

ХИМИЧИН ДАЙЧИН АХАН
ДҮҮСИЙН УУЛЗАЛТ



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит “Марш-тусгай” бэлтгэлийн цогцолбор тэмцээн, Зэвсэгт хүчний “Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор” тэмцээнээс хос алтан медаль хүртэж, хос цомын эзэд болж 2022 онд бэлтгэлээр халагдсан дайчид цэргийн алба хаасан ангидаа ирж цэргийн алба хааж буй дүү нараа эргэн, алба хаасан туршлагаа хуваалцлаа. Энэ үеэр тэдний дунд галын бэлтгэлийн нормативын тэмцээн, хөгжөөнт тоглоом, яруу найргийн уралдаан зохион байгуулж нэгэн өдрийг өрсөлдөөнтэй, дурсамж дүүрэн өнгөрүүлээ.

Дэслэгч Б.ОЮУНБИЛЭГ



АХМАДУУДДАА ХҮНДЭТГЭЛ
ҮЗҮҮЛЭВ



Цэргийн тагнуулын болон Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн хамт олон ахмад дайчдаа хүлээн авч хүндэтгэл үзүүлээ. Тус өдөрлөгт ангийн удирдлагууд, эл ангиас гавьяаныхаа амралтад гарсан бэлтгэл офицер, ахлагч, ажилтан алба хаагчдын төлөөлөл оролцлоо. Эл арга хэмжээг нээж Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн захирагч хурандаа Ч.Алтангэрэл үг хэлж ангийнхаа өнгөрсөн онд хийж

хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ ололт, амжилтаа товч танилцуулсны зэрэгцээ хүрэлцэн ирсэн ахмад дайчдаа баяр хүргэж хүндэтгэлийн зоог барьсан юм. Мөн энэ үеэр ахмадын зөвлөлийн дарга бэлтгэл дэд хурандаа Ц.Дарамбазар ахмадын зөвлөлийнхөө үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг бие бүрэлдэхүүнд тайлагналаа.

Дэслэгч Д.НИНЖБАДГАР